



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/179/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор
2025 оны 02 дугаар сарын 25

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Ахлах аудитор: М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Ахлах аудитор: Н.Батчимэг
Утас: 91113253 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал.....	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	20
4.5.1 Завсрын аудитын талаар.....	20
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	24

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2025.02.25 № 2/27
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Өлзийт сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

5020372

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баянхонгор аймгийн Өлзийт сумын ЗДТГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 14 зорилтын хүрээнд 111 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын Засаг дарга 93.0 хувиар үнэлсэн байна.

Баянхонгор аймгийн Өлзийт сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>230,723,914.25</u>	<u>259,305,936.61</u>
33	АВЛАГА	00.00	11,904,506.36
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	11,904,506.36
35	БАРАА МАТЕРИАЛ	230,723,914.25	247,401,430.25
351	Түүхий эд материал	85,054,900.00	88,664,100.00
35110	Тусгай зориулалттай материал	85,054,900.00	88,664,100.00
354	Хангамжийн материал	130,306,754.25	148,528,625.25
35410	Бичиг хэргийн материал	1,703,575.00	1,679,575.00
35420	Аж ахуйн материал	20,310,724.25	38,492,545.25
35470	Бусад хангамжийн материал	108,292,455.00	108,356,505.00
35600	Мал амьтад	15,362,260.00	10,208,705.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6,109,915,453.59</u>	<u>6,543,504,142.41</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,109,915,453.59	6,543,504,142.41
392	Биет хөрөнгө	6,022,861,453.47	6,455,313,547.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,383,753,978.11	7,055,852,282.11
39202	Хуримтлагдсан элэгдэл	-794,525,149.24	-1,085,516,433.35
39203	Авто-тээврийн хэрэгсэл	323,490,080.00	358,837,857.67
39204	Хуримтлагдсан элэгдэл	-154,858,056.81	-182,598,114.16
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	404,406,719.00	486,414,716.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	-195,922,560.39	-270,714,466.67
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	135,112,054.35	182,497,054.35
39208	Хуримтлагдсан элэгдэл	-86,985,411.55	-97,849,149.63
39216	Дуусаагүй барилга, байгууламж	7,400,000.00	7,400,000.00
39217	Ном	989,800.00	989,800.00
393	Биет бус хөрөнгө	87,054,000.12	88,190,595.16
39301	Програм хангамж	1,434,000.00	1,434,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,434,000.00	-1,434,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	112,824,000.00	122,550,595.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-25,769,999.88	-34,359,999.84
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>6,340,639,367.84</u>	<u>6,802,810,079.02</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>5,413,372.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	5,413,372.00
413	Өглөг	00.00	5,413,372.00
4136	Бусад өглөг	00.00	5,413,372.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	5,413,372.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>6,340,639,367.84</u>	<u>6,797,396,707.02</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	6,340,639,367.84	6,797,396,707.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	783,673,589.00	783,673,589.00
51101	Өмч: - төрийн	783,673,589.00	783,673,589.00
512	Хуримтлагдсан үр дүн	5,380,377,593.94	5,837,134,933.12
51210	Өмнөх үеийн үр дүн	5,380,377,593.94	5,380,377,593.94

Баянхонгор аймгийн Өлзийт сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	456,757,339.18
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	176,588,184.90	176,588,184.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>6,340,639,367.84</u>	<u>6,802,810,079.02</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,658,067,956.36	2,602,928,459.46
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	438,078,584.00	1,021,153,409.60
120	Нийтлэг татварын бус орлого	438,078,584.00	1,021,153,409.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,396,800.00	18,468,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,396,800.00	18,468,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,219,989,372.36	1,581,775,049.86
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,974,864.36	75,979,749.86
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,688,420.00	62,809,743.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,286,444.36	13,170,006.36
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,198,014,508.00	1,505,795,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,198,014,508.00	1,505,795,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,454,408,837.11	2,146,171,120.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,454,408,837.11	2,146,171,120.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,258,704,709.26	1,776,199,266.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	443,581,713.26	700,659,965.90
210101	Үндсэн цалин	255,059,299.84	370,487,005.84
210102	Нэмэгдэл	157,908,579.42	284,194,710.06
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,202,534.00	7,794,950.00
210104	Урамшуулал	00.00	24,341,900.00
210105	Гэрээт ажлын хөлс	23,411,300.00	13,841,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,579,870.71	88,558,514.18
210201	Тэтгэврийн даатгал	37,817,648.93	60,105,742.16
210202	Тэтгэмжийн даатгал	4,445,028.58	7,107,082.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,551,622.71	3,624,950.20
210204	Ажилгүйдлийн даатгал	886,513.97	3,558,017.36
210205	Эрүүл мэндийн даатгал	8,879,056.52	14,162,722.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82,173,528.34	94,037,903.30
210301	Гэрэл, цахилгаан	35,808,478.34	39,317,578.30
210302	Түлш, халаалт	45,865,050.00	54,720,325.00
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	127,185,138.20	246,328,213.00
210401	Бичиг хэрэг	5,029,700.00	5,770,100.00
210402	Тээвэр, шатахуун	31,110,777.00	41,046,994.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,784,115.20	4,807,000.00

Баянхонгор аймгийн Өлзийт сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
210404	Ном, хэвлэл	294,000.00	352,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,931,990.00	2,004,129.00
210408	Бараа материал акталсны зардал	17,616,790.00	7,361,905.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	66,177,766.00	184,745,585.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,525,000.00	15,121,000.00
210604	Урсгал засвар	10,525,000.00	15,121,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,678,000.00	6,099,600.00
210702	Дотоод албан томилолт	4,678,000.00	6,099,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,195,744.00	61,632,760.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,226,360.00	60,241,501.00
210803	Даатгалын үйлчилгээ	457,384.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	277,000.00	641,259.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	235,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	495,785,714.75	563,761,309.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	130,561,060.00	132,789,324.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,067,000.00	2,110,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	364,157,654.75	428,861,985.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	195,704,127.85	369,971,854.12
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	9,889,987.47
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	9,889,987.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,630,000.00	91,074,959.50
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	35,332,272.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	45,436,687.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,630,000.00	10,306,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	173,375,121.49	269,006,907.15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	173,375,121.49	269,006,907.15
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,699,006.36	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,699,006.36	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>203,659,119.25</u>	<u>456,757,339.18</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	84,820,950.06	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,660,250.06	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	79,160,700.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-84,820,950.06	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>118,838,169.19</u>	<u>456,757,339.18</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,243,413,372.36</u>	<u>1,600,243,049.86</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,424,000.00	18,468,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	23,424,000.00	18,468,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,424,000.00	18,468,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,424,000.00	18,468,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,219,989,372.36	1,581,775,049.86
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,974,864.36	75,979,749.86
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,688,420.00	62,809,743.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,286,444.36	13,170,006.36
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,198,014,508.00	1,505,795,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,198,014,508.00	1,505,795,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,068,522,572.36</u>	<u>1,547,088,149.86</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,068,522,572.36	1,547,088,149.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	872,818,444.51	1,170,625,161.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	443,581,713.26	700,659,965.90
210101	Үндсэн цалин	255,059,299.84	370,487,005.84
210102	Нэмэгдэл	157,908,579.42	284,194,710.06
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,202,534.00	7,794,950.00
210104	Урамшуулал	00.00	24,341,900.00
210105	Гэрээт ажлын хөлс	23,411,300.00	13,841,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,579,870.71	88,567,514.18
210201	Тэтгэврийн даатгал	37,817,648.93	60,114,742.16
210202	Тэтгэмжийн даатгал	4,445,028.58	7,107,082.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,551,622.71	3,624,950.20
210204	Ажилгүйдлийн даатгал	886,513.97	3,558,017.36
210205	Эрүүл мэндийн даатгал	8,879,056.52	14,162,722.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82,173,528.34	94,037,903.30
210301	Гэрэл, цахилгаан	35,808,478.34	39,317,578.30
210302	Түлш, халаалт	45,865,050.00	54,720,325.00
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,389,411.20	54,174,166.00
210401	Бичиг хэрэг	5,029,200.00	5,725,000.00
210402	Тээвэр, шатахуун	31,110,777.00	41,046,369.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,784,115.20	4,807,000.00
210404	Ном, хэвлэл	294,000.00	352,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00

Баянхонгор аймгийн Өлзийт сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,931,319.00	2,003,297.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,081,000.00	16,402,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	390,000.00	1,744,900.00
210604	Урсгал засвар	10,691,000.00	14,657,100.00
2107	Томилолт, зочны зардал	4,510,000.00	6,099,600.00
210702	Дотоод албан томилолт	4,510,000.00	6,099,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,154,467.00	66,229,510.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,185,083.00	64,838,251.00
210803	Даатгалын үйлчилгээ	457,384.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	277,000.00	641,259.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	235,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	191,348,454.00	144,454,502.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	189,823,379.00	142,344,502.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,525,075.00	2,110,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	195,704,127.85	376,462,988.48
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	9,889,987.47
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	9,889,987.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,630,000.00	85,661,587.50
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	29,918,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	45,436,687.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,630,000.00	10,306,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	173,375,121.49	269,006,907.15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	173,375,121.49	269,006,907.15
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,699,006.36	11,904,506.36
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,699,006.36	11,904,506.36
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>174,890,800.00</u>	<u>53,154,900.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	174,890,800.00	53,154,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	174,890,800.00	53,154,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	174,890,800.00	53,154,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	174,890,800.00	53,154,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-174,890,800.00</u>	<u>-53,154,900.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	771,855,589.00	95,527,357.09	150,008,585.03	00.00	1,017,391,531.12
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	771,855,589.00	95,527,357.09	150,008,585.03	00.00	1,017,391,531.12
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	734,911,537.01	00.00	734,911,537.01
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	783,673,589.00	176,588,184.90	5,380,377,593.94	00.00	6,340,639,367.84
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	783,673,589.00	176,588,184.90	5,380,377,593.94	00.00	6,340,639,367.84
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	783,673,589.00	176,588,184.90	5,380,377,593.94	00.00	6,340,639,367.84
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	456,757,339.18	00.00	456,757,339.18
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	783,673,589.00	176,588,184.90	5,837,134,933.12	00.00	6,797,396,707.02

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,622,426,300.00	1,255,256,392.85	367,169,907.15	77.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,622,426,300.00	1,255,256,392.85	367,169,907.15	77.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,522,157,400.00	1,185,341,505.38	336,815,894.62	77.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	725,561,200.00	700,659,965.90	24,901,234.10	96.6
210101	Үндсэн цалин	371,807,300.00	370,487,005.84	1,320,294.16	99.6
210102	Нэмэгдэл	306,820,600.00	284,194,710.06	22,625,889.94	92.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,750,000.00	7,794,950.00	955,050.00	89.1
210104	Урамшуулал	24,341,900.00	24,341,900.00	00.00	100.0
210105	Гэрээт ажлын хөлс	13,841,400.00	13,841,400.00	00.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,695,300.00	88,567,514.18	2,127,785.82	97.7
210201	Тэтгэврийн даатгал	61,672,800.00	60,114,742.16	1,558,057.84	97.5
210202	Тэтгэмжийн даатгал	7,255,600.00	7,107,082.02	148,517.98	98.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,627,800.00	3,624,950.20	2,849.80	99.9
210204	Ажилгүйдлийн даатгал	3,627,800.00	3,558,017.36	69,782.64	98.1
210205	Эрүүл мэндийн даатгал	14,511,300.00	14,162,722.44	348,577.56	97.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	95,147,600.00	94,037,903.30	1,109,696.70	98.8
210301	Гэрэл, цахилгаан	40,000,000.00	39,317,578.30	682,421.70	98.3
210302	Түлш, халаалт	55,147,600.00	54,720,325.00	427,275.00	99.2
2104	Хангамж, бараа материалын зардал	55,267,400.00	54,174,166.00	1,093,234.00	98.0

Баянхонгор аймгийн Өлзийт сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан					
210401	Бичиг хэрэг	5,776,600.00	5,725,000.00	51,600.00	99.1
210402	Тээвэр, шатахуун	41,600,000.00	41,046,369.00	553,631.00	98.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,960,000.00	4,807,000.00	153,000.00	96.9
210404	Ном, хэвлэл	650,800.00	352,500.00	298,300.00	54.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00	00.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,040,000.00	2,003,297.00	36,703.00	98.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,300,000.00	30,256,900.00	43,100.00	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,600,000.00	15,599,800.00	200.00	100.0
210604	Урсгал засвар	14,700,000.00	14,657,100.00	42,900.00	99.7
2107	Томилолт, зочны зардал	6,307,700.00	6,099,600.00	208,100.00	96.7
210702	Дотоод албан томилолт	6,307,700.00	6,099,600.00	208,100.00	96.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	66,253,200.00	53,464,010.00	12,789,190.00	80.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	64,716,200.00	52,072,751.00	12,643,449.00	80.5
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	500,000.00	00.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	727,000.00	641,259.00	85,741.00	88.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	310,000.00	250,000.00	60,000.00	80.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	452,625,000.00	158,081,446.00	294,543,554.00	34.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	450,515,000.00	155,971,446.00	294,543,554.00	34.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,110,000.00	2,110,000.00	00.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100268900.00	69914887.47	30,354,012.53	69.7
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	60,000,000.00	29,689,987.47	30,310,012.53	49.5
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	60,000,000.00	29,689,987.47	30,310,012.53	49.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,268,900.00	40,224,900.00	44,000.00	99.9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,918,900.00	29,918,900.00	00.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,350,000.00	10,306,000.00	44,000.00	99.6
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,505,795,300.00	1,524,263,300.00	-18,468,000.00	101.2
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,505,795,300.00	1,505,795,300.00	00.00	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	1,505,795,300.00	1,505,795,300.00	00.00	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	18,468,000.00	-18,468,000.00	#DIV/0!
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	18,468,000.00	-18,468,000.00	#DIV/0!

Баянхонгор аймгийн Өлзийт сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	25.00	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	09.00	09.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	00.00	100.0

2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	64,075,243.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	64,075,243.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	18,638,556.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,265,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,265,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,373,056.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,373,056.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,436,687.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,436,687.50
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	45,436,687.50
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	75,979,749.86
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	75,979,749.86
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	62,809,743.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,170,006.36
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	11,904,506.36
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Өлзийт сумын ЗДТГ нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль хэрэгжүүлэн ажилладаг сумын Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд чиглэгдсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгэм төрийн захиргааны байгууллагын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөр төсөл боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх, холбогдох арга хэмжээг зохицуулах чиг үүрэгтэй ажилладаг.

Баянхонгор аймгийн Өлзийт сумын ЗДТГ нь орчин үеийн тэргүүний дэвшилтэт технологи нэвтэрсэн өндөр мэргэжилтэй, чадварлаг боловсон хүчний чадварт түшиглэн төрийн үйлчилгээг үзүүлэх 13 зорилгын хүрээнд хөдөө аж ахуйн, санхүү, багийн засаг дарга, ЗДТГ-ын албан хаагч гэсэн бүтэцтэйгээр 25 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Дарга М.Зоригт, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ч.Батдорж нар зурж, нярваар М.Батболд нар ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоол
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 82 дугаар тогтоол (Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам)
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Журам батлах, журмын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 83 дугаар тогтоол (Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам)

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүргийг үүргийг Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хэрэгжүүлдэг ба 2022, 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Өлзийт сумын ЗДТГ нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын үйл ажиллагаандаа мөрддөг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг”-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Өлзийт сумын ЗДТГ нь 2024 оны санхүүгийн тайланг УСНББОУС-1 стандартын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн Өлзийт сумын ЗДТГ-ын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 6,802,810.1 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 462,170.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	230,723.9	259,305.9	28,582.0
Авлага	0.0	11,904.5	11,904.5
Бараа материал	230,723.9	247,401.4	16,677.5
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,109,915.5	6,543,504.1	433,588.6
Үндсэн хөрөнгө	7,369,410.6	8,215,976.3	846,565.7
Хуримтлагдсан элэгдэл	(1,259,495.2)	(1,672,472.2)	(412,977.0)
Нийт хөрөнгө	6,340,639.4	6,802,810.1	462,170.7
Өр төлбөр	0.0	5,413.4	5,413.4
Засгийн газрын хувь оролцоо (Эздийн өмч)	6,340,639.4	6,797,396.7	456,757.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,340,639.4	6,802,810.1	462,170.7

Дээрх хүснэгтээс харахад, авлага дансны үлдэгдэл 11,904.5 мянган төгрөг байгаа нь нэмэлт санхүүжилтийн дансны төвлөрүүлсэн үлдэгдлийг авлагаар тусгасантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 247,401.4 мянган төгрөг болж өмнөх оноос 16,677.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 144,014.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар бусад байгууллагаас 193,389.6 мянган төгрөгийн бараа материал хүлээн авч, 7,361.9 мянган төгрөгийн бараа материалыг даргын 2024 оны А/31 дүгээр тушаалаар акталж, үйл ажиллагаандаа 313,364.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,215,976.3 мянган төгрөг болж 846.565.7 мянган төгрөгөөр өссөн нь тайланд онд төсвийн хөрөнгөөр 53,154.9 мянга, ахмадын өргөө, 5 дугаар багийн барилга, стадионд 184,812.0 мянган төгрөгийн сайжруулалт хийж, сум байгуулагдсаны 100 жилийн ойн хөрөнгө оруулалтаар 71,733.7 мянга, аймгийн ОНХС-аар 1,193.6 мянга, сумын ОНХС-аар 181,517.7 мянга, УТХО-аар 89,453.5 мянга, сумын Соёлын төвөөс 297,624.7 мянга, ХХААГ-аас 4,600.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, 8,360.6 мянган төгрөгийн газар бүртгэж, аймгийн ИТХ-ын даргын 2024 оны 38 дугаар захирамжаар 15,885.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 456,757.3 мянган төгрөгөөр өсөж 6,797,396.7 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь

тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,438,084.8 мянга, өөрийн үйл ажиллагааны орлогоос 16,000.0 мянга нийт 1,454,084.8 мянган төгрөгөөр санхүүжүүлэх, нийт зарлагыг 1,454,084.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төсөлд 2 удаа тодотгол хийж орон нутгийн төсвөөс 1,505,795.3 мянга, өөрийн үйл ажиллагааны орлогоос 16,000.0 мянга нийт 1,521,795.3 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 1,505,795.3 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,505,795.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, өөрийн үйл ажиллагааны орлогоос 16,000.0 мянган төгрөг оруулахаар төвлөснөөс гүйцэтгэлээр 18,468.0 мянган төгрөг төвлөрсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,236,788.5 мянган төгрөг буюу 82.1 хувьтай байгаа нь үйл ажиллагааны зардлын төсвийг 269,006.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Орон нутгийн төсөв					
1	70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	1,505,795.3	1,236,788.5	269,006.8	82.1
1.1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	843,507.7	798,472.3	45,035.4	94.7
1.2	80106 Баг, хорооны үйл ажиллагааны зардал	205,794.7	203,372.8	2,421.9	98.8
1.3	80513 Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	60,000.0	29,690.0	30,310.0	49.5
1.4	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	39,668.9	39,658.9	10.0	100.0
1.5	81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	87,000.0	80,825.3	6,174.7	92.9
1.6	81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал	246,204.0	61,764.2	184,439.8	25.1
1.7	82201 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны зардал	7,680.0	7,680.0	0.0	100.0
1.8	82212 Хур хог хаягдал орчны бохирдлыг устгах зардал	14,940.0	14,907.0	33.0	99.8
1.9	82310 Гамшгаас сэргийлэх сургалт сурталчилгаа	1,000.0	418.0	582.0	41.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Үндсэн үйл ажиллагааны зардлаас 45,035.4 мянга буюу 5.3 хувь, баг хорооны үйл ажиллагааны зардлаас 2,421.9 мянга буюу 1.2 хувь, орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалтаас 30,310.0 мянга буюу 50.5 хувь, орон нутгийн нөөц хөрөнгөөс 6,174.7 мянга буюу 7.1 хувь, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 184,439.8 мянга буюу 74.9 хувь, хур хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах зардлаас 33.0 мянга буюу 0.2 хувь, гамшгаас сэргийлэх сургалт сурталчилгааны зардлаас 582.0 мянга буюу 58.2 хувь нийт 269,006.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 13,170.0 мянга, дээд шатны төсөв захирагчаас 62,809.7 мянга нийт 75,979.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 45,436.7 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 3,373.1 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 15,265.5 мянга, нийт 64,075.2 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 11,904.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ЗДТГ-ын шатах тослох материал худалдан авах 44,790.0 мянга, 1,2,4-р багт тарвага нутагшуулах 40,000.0 мянган төгрөгийн 2 тендерийг харьцуулалтын аргаар зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

ЗДТГ-ын шатах тослох материал худалдан авах тендерт “Гүнзэгэстэй” ХХК шалгарч гэрээ байгуулан тайлант онд тус компаниас 41,046.4 мянган төгрөгийн шатахуун худалдан авсан байна.

Өлзийт сумын 1,2,4-р багт тарвага нутагшуулах 40,000.0 мянган төгрөгийн тендерт оролцогч шалгараагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Өлзийт сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Өлзийт сумын ЗДТГ нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дугаар сарын 06-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсөв 1,505,795.3 мянган төгрөгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 854,500.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 15,058.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 9,797.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сумын Засаг даргын 2024.12.27-ны өдрийн “нэг удаагийн дэмжлэг олгох тухай” Б/28 дугаар захирамжаар үр бүтээлтэй ажилласан өмнөх Засаг даргад нэг удаагийн буцалтгүй тусламжид 2,145.0 мянган төгрөгийг олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2024 онд 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 166 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 5 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 41,575.0 мянган төгрөгийн 6 гүйлгээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант оны 12 сард эхний 3 дугаар улирлын байдлаар завсрын аудит хийхэд бараа материалын тайлангийн эхний үлдэгдлийг зөрүүтэй гаргасныг залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 700.0 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 700.0 мянган төгрөгийн төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлсэн байна. Шийдвэрийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад ирүүлснийг биелэлтийг тооцож FAS системд оруулсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	700.0	1	700.0	100
Албан шаардлага	1	0.0	1	0.0	100
Нийт дүн	2	700.0	2	700.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 46,948.0 мянган төгрөгийн 4 зөрчил¹ илэрснээс, 758.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 46,190.0 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлсэн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс материаллаг зөрчил нь 5,733.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 9,797.7 мянган төгрөгийн гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс 4,424.7 мянган төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Өлзийт сумын 100 жилийн ойн хандивын дансны үлдэгдэл 758.0 (долоон зуун тавин найман мянга) төгрөгийг сумын ОНХС-ийн дансанд төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4 дэх "Төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", 7 дугаар зүйлийн 7.7 дахь "энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", 60 дугаар зүйлийн 60.2.5 дахь "тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өлзийт сумын 100 жилийн ойн арга хэмжээний хандиваас үлдсэн 758.0 (долоон зуун тавин найман мянга) төгрөгийг сумын орон нутгийн хөгжлийн сангийн 100031452400 тоот дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1. "Дурсамж принт" ХХК-д 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдөр 2021 онд хэвлэгдсэн өглөгөөр тусгаагүй "Өрхтэй харилцах дэвтрийн үнэ"-д 2,470.0 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид санхүүгийн тайланд тусгагдаагүй тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй гүйлгээ хийхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.2. Сумын Засаг даргын 2024.12.27-ны өдрийн "нэг удаагийн дэмжлэг олгох тухай" Б/28 дугаар захирамжаар үр бүтээлтэй ажилласан өмнөх Засаг даргад нэг удаагийн буцалтгүй тусламжид 2,145.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлагыг өгөв.

5.2.3. Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 41,575.0 мянган төгрөгийн 6 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 дахь "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх орхигдуулсан мэдээллийг байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэх албан шаардлагыг өгөв.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өлзийт сумын 100 жилийн ойн хандивын дансны үлдэгдэл 758.0 (долоон зуун тавин найман мянга) төгрөгийг ОНХС-ийн дансанд төвлөрүүлээгүй байна.	1	758.0	1	758.0	-	-	-	-
"Дурсамж принт" ХХК-д 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдөр 2021 онд үйлдвэрлэсэн өмнөх онд өглөгөөр тусгаагүй "Өрхтэй харилцах дэвтрийн үнэ"-д 2,470.0 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас шилжүүлсэн байна.	1	2,470.0	-	-	1	2,470.0	-	-
Сумын Засаг даргын 2024.12.27-ны өдрийн "нэг удаагийн дэмжлэг олгох тухай" Б/28 дугаар захирамжаар үр бүтээлтэй ажилласан өмнөх Засаг даргад нэг удаагийн буцалтгүй тусламжид 2,145.0 мянган төгрөгийг олгосон байна.	1	2,145.0	-	-	1	2,145.0	-	-
Дүн	3	5,373.0	1	758.0	2	4,615.0	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил								
Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 41,575.0 мянган төгрөгийн 6 гүйлгээг мэдээлээгүй байна.	1	41,575.0	-	-	1	41,575.0	-	-
Дүн	1	41,575.0	-	-	1	41,575.0	-	-

-----oOo-----